



МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 25 өдөр


дугаар A/07


Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 7.2, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтооолоор батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 1.4.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний үйл ажиллагаанд, дотоод хяналт шалгалт зохион байгуулах журмыг хавсралтаар баталсугай.
- Энэ тушаал гарсантай холбогдуулан Хууль зүйн Сайдын 2013 оны А/71, А/235, А/161, 2015 оны А/236, 2016 оны А/135, А/219 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
- Энэхүү журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Баясалан/-д үүрэг болгосугай.





ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН  
ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНД ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

**Нэг. Нийтлэг зүйл**

1.1 Энэхүү журмын зорилго нь Хууль зүй, дотоод хэргийн яам, түүний харьяа агентлаг, байгууллагын сахилга дэг журмыг бэхжүүлэх, ажлын үр дүнг дээшлүүлэх, эрсдлийг бууруулах, зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх, түүнийг арилгах зорилгоор дотоод хяналт шалгалтыг нэгдсэн удирдлагаар хангах, зохион байгуулах, үр дүнг нэгтгэн танилцуулах, тайлганахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2 Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахдаа Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” болон энэхүү журмыг удирдлага болгоно.

**Хоёр. Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах зарчим, зорилго, хамрах хүрээ**

2.1 Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахдаа Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан болон Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 2.1-д заасан хууль дээдлэх, хараат бус, ил тод, шударга, бодитой, хөндлөнгийн аливаа нөлөөллөөс ангид байх зарчмыг баримтална.

2.2 Дотоод хяналт шалгалтын зорилго нь яам, харьяа агентлаг, байгууллагаас иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээг хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны болон тухайн байгууллагын удирдлагын гаргасан шийдвэрт нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, зөвлөмж өгөх, буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэхэд оршино.

2.3 Дотоод хяналт шалгалтыг зохих төлөвлөгөөний дагуу батлагдсан удирдамжаар гүйцэтгэнэ.

**Гурав. Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нэгж, ажилтан, түүний эрх үүрэг**

3.1 Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах чиг үүргийг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газар, харьяа агентлаг, байгууллагын Тамгын газар /цаашид “Дотоод хяналтын нэгж” гэх/ хариуцан гүйцэтгэнэ.

3.2 Дотоод хяналт шалгалтын нэгж нь хийсэн дотоод хяналт шалгалтын талаар бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бурдүүлж, удирдлагыг холбогдох мэдээллээр хангана.

3.3 Хяналт шалгалтыг төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн гэсэн хэлбэрээр зохион байгуулна.

3.4 **Төлөвлөгөөт хяналт шалгалтыг** Хууль зүй, дотоод хэргийн яам, агентлаг байгууллагын тухайн жилийн дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгаж, **төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг** Төрийн хяналт шалгалтын тухай хуулинд заасан үндэслэлээр тус тус хийнэ.

3.5 **Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг** өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах зорилгоор хийнэ.

3.6 Яамны хэмжээнд хийх хяналт шалгалтыг Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар, харьяа агентлаг, байгууллага дотоод хяналт шалгалтыг тухайн агентлаг байгууллагын даргын тушаалаар тус тус байгуулагдсан Ажлын хэсэг хийнэ.

3.7 Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг харьяа агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийж болно. Уг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын холбогдох мэргэжилтэнг тус тус оролцуулна.

3.8 Дотоод хяналт шалгалтын ажлын хэсэг нь дараах эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ.

3.8.1 зохих удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг хийж, дүнг илтгэх хуудсаар тайлагнах;

3.8.2 хяналт шалгалт явуулахдаа дотоод нэгж болон байгууллагын удирдлагатай шууд харилцаж, тэдгээрээс шаардлагатай мэдээ, судалгаа гаргуулан авч танилцах, холбогдох ажилтны ажлыг шалгаж танилцах, илэрсэн зөрчил дутагдлын талаар тайлбар гаргуулах;

3.8.3 илэрсэн зөрчил дутагдлын шалтгаан нөхцлийг тодруулан, зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах;

3.8.4 шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, зөрчил гаргасан этгээдэд хариуцлага ногдуулах талаар байгууллагын удирдлагад санал тавьж шийдвэрлүүлэх;

3.8.5 зөрчил, дутагдал гаргахаас сэргийлэх хууль тогтоомжийг нэг мөр мөрдөж ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;

3.8.6 мэдээллийн нууц хадгалах;

**Дөрөв. Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаа**

4.1 Дотоод хяналт шалгалтыг дараах чиглэлээр зохион байгуулна.

4.1.1 хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актын хэрэгжилт;

4.1.2 байгууллага, нэгжийн хуулиар хүлээсэн уүргийн хэрэгжилтэд тухайн байгууллага, нэгжийн үзүүлж байгаа ажил, үйлчилгээний чанар, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт;

4.1.3 хөдөлмөрийн дотоод журам болон бусад журам, дүрмийн хэрэгжилт;

4.1.4 ажлын цаг ашиглалтыг сайжруулах, хариуцлага, үр дүнг дээшлүүлэх, сахилга дэг журмыг бэхжүүлэх;

**Тав. Дотоод хяналт шалгалтын дүн**

5.1 Яамны хэмжээнд хийсэн хяналт шалгалтын дүн, авсан арга хэмжээний талаар яамны Удирдлагын зөвлөлийн, харьяа агентлаг, байгууллага үйл ажиллагаандын хийсэн хяналт шалгалтын дүн, авсан арга хэмжээний талаар даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, шаардлагатай бол зохих шийдвэр гаргаж хамт олонд танилцуулна.

5.2 Яамнаас харьяа агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хийсэн дотоод хяналт шалгалтын дүнг Сайдын шуурхай хуралдаанд танилцуулна.

-----оо-----